

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ**

**МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН
БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН
БАЙГУУЛЛАГЫН ЧАНАРЫН
ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/Орон нутгийн сургалтын байгууллагууд/

*Улаанбаатар хот
2024 он*

АГУУЛГА

НЭГ. МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ	3
1.1 Үндэслэл.....	3
1.2 Чанарын үнэлгээний судалгааны зорилго, зорилт.....	4
1.3 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын чанарыг үнэлэх судалгааны арга зүй, аргачлал	5
1.3.1 Үнэлгээний арга хэрэгслийн найдвартай байдал.....	8
1.3.2 Түүврийн хамрах хүрээ, хэмжээг тодорхойлох	9
1.3.3 Түүврийн хүрэлцээтэй байдал /КМО/.....	9
ХОЁР. ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	10
Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээ зохион байгуулах менежмент.....	10
ГУРАВ. ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ СУДАЛГААНЫ ЕРӨНХИЙ ҮР ДҮН	13
3.1 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчдаас авсан шалгалтын ерөнхий үр дүн	13
3.2 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын удирдах ажилтнаас авсан шалгалтын ерөнхий үр дүн	20
3.3 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нараас авсан шалгалтын ерөнхий үр дүн	25
ДӨРӨВ. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	30

НЭГ. МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭ

1.1 Үндэслэл

Монгол Улсын боловсролын зорилго нь хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, насан туршдаа суралцаж, ажиллах, ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэнийг төлөвшүүлэх юм. Харин мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын зорилго нь нийгмийн хөгжил, эдийн засгийн бүтээмжийг дэмжих, хөдөлмөрийн зах зээл, ур чадварын эрэлт, шаардлагад нийцсэн мэргэжлийн ур чадвар бүхий иргэн бэлтгэж, мэргэшлийн түвшин ахиулах, тасралтгүй хөгжих хэрэгцээг хангахад оршиж байна.

Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалт нь насан туршийн боловсролын нэг хэсэг болох бүрэн дунд боловсрол, дээд боловсролын түвшинд явагдах боломжтой бөгөөд ажлын талбарт суурилан суралцах, тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлдгээрээ бусад түвшний боловсролын сургалтаас ялгаатай байдаг.

2021 онд хийгдсэн хөдөлмөрийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдлын судалгааны зарим үр дүнгээс үзэхэд:

- хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагааны ажлын байрны захиалга 87.0 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн салбар 57.9 хувь, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарын ажлын байрны захиалга 36.0 хувиар өссөн бөгөөд техникийн салбарын хувьд энэ үзүүлэлт хамгийн өндөр хувийг эзэлж байна.

Тус тайланд "...ажил мэргэжлийн ангиллын хувьд "Энгийн ажил мэргэжил", "Мэргэжилтэн", "Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан", "Худалдаа, үйлчилгээний ажилтан" бүлгийн ажил мэргэжил нийт захиалгын 68.3 хувийг эзэлж байгааг мөн дурдсан байна.¹

- "хөдөлмөрийн зах зээлд дээд боловсролын ажил мэргэжлийн эрэлтээс илүү мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагаар бэлтгэгддэг ажил мэргэжлийн эрэлт өндөр байх хандлага хадгалагдсаар байна. Тодруулбал: тогооч, зөөгч, жолооч, гагнуурчин, цахилгаанчин гэх зэрэг ажил мэргэжлийн эрэлт жил бүрийн эрэлттэй ажил мэргэжлийн ангилалд тогтмол нэрлэгдсээр байна" гэдгийг тус тайланд онцлон тэмдэглэсэн байна.

Ажил олгогчид, ажил хайгчийн мэргэжлийн нарийн ур чадвар гэхээс илүүтэй хувь хүний зөөлөн ур чадварыг хамгийн чухал үзүүлэлт гэж үздэг хандлага хэвээр төдийгүй бие даан ажиллах чадвар, найдвартай, хариуцлагатай байдал, эерэг зөв хандлагатай байдал, харилцааны ур чадвар, цаг ашиглах чадварыг хамгийн ихээр чухалчилж үзсэн байна.

Харин мэргэжлийн хувьд төдийлөн өндөр шаардлага тавихгүй ч ажлын байрны аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэдлэг, ёс зүйтэй байх, шинэ санаа гаргах чадварыг илүүд үзэж боловсролын түвшний хувьд тодорхой хэмжээний боловсрол эзэмшсэн байх шаардлагыг тавих хандлага улам бүр өссөн нэмэгдэж байна.

Монгол Улс дахь ур чадварын эрэлт барометрийн 2022 оны судалгаанд дурдагдсан боловсролын тогтолцооны талаарх ажил олгогчдын үнэлгээгээр "ажил олгогчид Монголын боловсролын тогтолцооны үр дүнд шүүмжлэлтэй хандаж байгаагаа илэрхийлсэн" байна.

¹ Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа, 2021

Ажил олгогчдын дийлэнх буюу 80 орчим хувь нь боловсролын систем тэдний бизнесийн үйл ажиллагаанд нийцсэн ур чадвартай хүмүүсийг бэлтгэж чадахгүй байна гэж үзсэн байна.

Ялангуяа ТМБС-ын тогтолцооны үр дүнд шүүмжлэлтэй хандаж байгаа бөгөөд тухайлбал, техникийн ахисан түвшний шаардлагыг хангах, тухайн ажлын байранд тохирох ур чадвартай хүмүүсийг бэлтгэхгүй байгаад ажил олгогчид гомдолтой байна. Мөн түүнчлэн боловсролын байгууллагыг төгсөгчид орчин үеийн арга техник, технологийн талаарх мэдлэгээр дутмаг, ажлын байран дээрх хандлага нь сэтгэлд хүрдэггүй гэдгийг илэрхийлсэн байна.²

Боловсролын хөгжлийн чиг хандлага хүртээмжээс чанарт, мэдлэг хүлээн авагч, дамжуулагчаас мэдлэг бүтээгч, мэдлэгийг шүүн тунгаадаг хэрэглэгч, чадамж, чадавхыг хөгжүүлэгчийг бэлтгэх чиглэлээр өөрчлөгдөж байна. Өөрөөр хэлбэл багш төвтэй сурган заах арга зүйгээс суралцагч төвтэй арга зүйд шилжиж эхлээд байна. Ингэхдээ зөвхөн аль нэг талыг бус “оролт, үйл явц, гаралт”-ын түвшинд бүхэлд нь хэмжих, түүний үр нөлөөг судалдаг болж өөрчлөгдөж байна.

Хөдөлмөрийн зах зээл, ажил олгогчдын эрэлтэд нийцсэн мэдлэг, ур чадвар, чадамжтай, зөв хандлага, ёс зүйтэй ажилтан бэлтгэж буй сургалтын байгууллагын үйл ажиллагааны чанарыг тодорхой давтамжтайгаар үнэлэх, үнэлгээний үр дүнд үндэслэн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын чанар, багшийн тасралтгүй хөгжил, сургалтын байгууллагын менежментийг сайжруулах чиглэлээр бодлого, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай байгааг сүүлийн жилүүдийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгааны үр дүнгээс харуулж байна.

Иймээс Монгол Улсын хэмжээнд мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үйл ажиллагаа явуулж буй сургалтын байгууллагын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлж, сургалтын орчин болон хүний нөөцийн чадавх, мэргэжлийн хөтөлбөрийн хэрэгжилт, түүний үр дүнг үнэлэх үнэлгээг бүхэлд нь хамруулсан судалгааг зохион байгуулж суурь мэдээллийн сан үүсгэх зорилгоор энэ удаагийн чанарын үнэлгээний судалгааг зохион байгуулж, үр дүнг тайлагнаж байна.

1.2 Чанарын үнэлгээний судалгааны зорилго, зорилт

Аймаг, орон нутагт мэргэжлийн болон техникийн боловсролын үйл ажиллагаа явуулж буй сургалтын байгууллагын суралцагч нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажлын байрны шаардлагад нийцсэн чадамж эзэмшиж байгаа эсэхийг нийтлэг мэргэжил бүрийн сургалтын /чадамжийн/ хөтөлбөр, багшийн мэдлэг, ур чадвар, сургалтын орчин, сургалтын чанарт үнэлгээ хийх замаар тодорхойлоход оршино. Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг биелүүлэхэд анхаарч ажилласан.

Үүнд:

1. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын чанарыг үнэлэх арга зүйн хүрээ, дизайныг боловсруулах;
2. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын хүний нөөц /удирдах ажилтан, багш/-ийн мэдлэг, ур чадварыг үнэлэх арга хэрэгслийг боловсруулж, үнэлгээ, дүгнэлт хийх;
3. Сургалтын байгууллагын орчин, хүртээмж, холбогдох стандартын хэрэгжилт, дадлагын орчин, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөц, эдгээрийн


² Монгол улс дахь ур чадварын эрэлт, 2022 он, 6-р хуудас

- ашиглалтын талаарх судалгааны маягт боловсруулан мэдээлэл цуглуулж дүгнэлт гаргах;
4. Чадамжид суурилсан хичээл, сургалтын үйл ажиллагааны бэлтгэл, явц, суралцагчийн эзэмшиж буй чадамжийн түвшнийг үнэлэх шалгалтын материал боловсруулах, үр дүнг үнэлж дүгнэлт гаргах;
 5. Суралцагч, төгсөгч болон ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа хийж дүгнэлт гаргах.

1.3 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын чанарыг үнэлэх судалгааны арга зүй, аргачлал


Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээг **ГУРВАН ХЭСГИЙН ЗАГВАР** буюу **Оролт-Үйл явц-Гаралт** гэсэн байдлаар төлөвлөж шалгуур, үзүүлэлт бүрээр нарийвчилсан үзүүлэлт, нотлох баримт цуглуулах арга хэрэгслийг боловсруулан үнэлгээг зохион байгууллаа.

Зураг 1. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээний ерөнхий чиглэл, хүрээ




Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээний ерөнхий чиглэл, хүрээнд нийцүүлэн судалгаа зохион байгуулах тойм зураглалыг гарган үйл ажиллагааг зохион байгуулсан.

Зураг 2. Чанарын үнэлгээний судалгаа зохион байгуулах тойм зураглал



Чанарын үнэлгээний судалгааны ерөнхий чиглэл, хүрээ, зохион байгуулах тойм зураглалд нийцүүлэн судалгааны арга зүйг боловсруулахдаа дараах процессын зураглалын дагуу үйл ажиллагааг төлөвлөсөн хэрэгжүүлсэн.

Зураг 3. Судалгааны арга хэрэгсэл боловсруулах үе шат



Үнэлгээний арга хэрэгсэл боловсруулах үйл ажиллагааг үндсэн 2 хэсэгт ангилсан бөгөөд нэгдүгээрт суралцагч, багш, удирдах ажилтнаас авах бичгийн шалгалтын материал боловсруулах, хоёрдугаарт асуулга судалгаа, хяналтын хуудас боловсруулах гэсэн чиглэлээр мэргэжлийн дэд багуудыг бүрдүүлэн ажилласан.

Чанарын үнэлгээний ашигласан үнэлгээний арга хэрэгсэл нь үндсэн 6 төрлөөр боловсруулагдсан байна.

Үүнд:

- Бичгийн шалгалт
- Асуулга судалгаа
- Бичгийн шалгалт
- Хичээл ажиглалт
- Фокус бүлгийн ярилцлага
- Орчны үнэлгээ
- Сэтгэл ханамжийн судалгааны мэдээлэл цуглуулах зорилгоор боловсруулагдсан.

Бичгийн шалгалт нь багш, суралцагч, удирдах ажилтан гэсэн 3 чиглэлээр боловсруулагдан шалгалтын дэвтрээр буюу цаасан суурьтай зохион байгуулагдсан.

Асуулга, ажиглалтын хуудас болон фокус бүлгийн ярилцлагыг дараах зорилтот бүлгийн хүрээнд тэдний ажил мэргэжлийн чиг үүрэг, албан тушаалын тодорхойлолт болон салбарын хэмжээнд хэрэгжүүлж буй бодлого, төлөвлөлт тэдгээрийн хэрэгжилтийг судлах зорилгоор боловсруулсан. Үүнд:

- ✚ Сургалтын байгууллагын удирдах ажилтны асуулга
- ✚ Багшийн асуулга
- ✚ Суралцагчийн асуулга
- ✚ Эцэг, эх, асран хамгаалагчийн асуулга
- ✚ Орчны стандартын хэрэгжилтийг үнэлэх хуудас
- ✚ Онолын болон дадлагын хичээл ажиглалтын хуудас
- ✚ Төгсөгч болон ажил олгогч нартай хийх ярилцлага
- ✚ Төгсөгч болон ажил олгогчоос авах асуулга гэсэн чиглэлээр тус бүр үнэлгээний хэрэгсэл боловсруулан үнэлгээг зохион байгуулсан.

Чанарын үнэлгээний арга зүй, аргачлалыг тодорхойлох зорилгоор 2 удаагийн хэлэлцүүлэг, 1 удаагийн сургалт, 2 удаагийн боловсруулах түвшинд сургалт семинар зохион байгуулсан.

Бичгийн болон ур чадварын шалгалтын материал боловсруулах

- Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багшаас авах бичгийн шалгалтын агуулгыг эх хэл, хууль эрх зүйн мэдлэг, цахим ур чадварыг үнэлэх агуулгатай байхаар төлөвлөсөн. Дээрх агуулгаар даалгавар боловсруулах багийг томилж бюпринтийн төлөвлөлтөд эх хэл 40 хувь хууль эрх зүй 30 хувь, цахим ур чадвар 30 хувь байхаар төлөвлөж боловсруулалтыг хийсэн.
- Суралцагчаас авах бичгийн шалгалтыг сонгосон чадамжийн хөтөлбөрийн хүрээнд онолын мэдлэг болон ур чадварын гэсэн 2 хэсэгтэйгээр даалгавар боловсруулсан. Онолын мэдлэгийг сонгох хэлбэрийн даалгавартай байхаар төлөвлөж боловсруулсан бол ур чадварын даалгавар нь чадамжийн хөтөлбөр дэх үнэлгээний шалгуурт баримжаалан боловсруулагдсан.
- Удирдах ажилтнаас авах бичгийн шалгалтын агуулга нь эх хэл 31 хувь, эрх зүй 38 хувь, цахим ур чадвар 31 хувь байхаар бюпринтийн төлөвлөлтийг хийсэн. Дээрх 2 чиглэлээр сорил даалгавар боловсруулах баг, экспертийн багийг томилж сэдэв даалгавар боловсруулах, нууцлалыг ханган ажиллах гэрээг байгуулж ажилласан.

Чанарын үнэлгээний бусад арга хэрэгсэл боловсруулах

- Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээний асуулга судалгаанд суралцагч, багш, удирдах ажилтан, ажил олгогч, эцэг эх, тухайн сургалтын байгууллагын төгсөгчийг хамруулахаар тооцож асуулгыг боловсруулсан. Дээрх 6 чиглэл тус бүрээр 2-оос 3 хүний бүрэлдэхүүнтэй баг томилогдон боловсруулалтын ажлыг гүйцэтгэсэн. Ингэхдээ асуулгын агуулгыг нарийвчлан тодорхойлж, асуулгаар тодруулах чиглэлийг тохирсон ба асуулгын дараах статистик үр дүнд фактор анализ хийхэд найдвартай байхад анхаарч ажиллах чиглэлийг өгсөн болно.
- Чанарын үнэлгээний мэдээлэл цуглуулах арга хэрэгслийн нэг болох фокус ярилцлагыг суралцагч, багш, удирдах ажилтан, ажил олгогч, төгсөгчтэй хийхээр оролцогчдыг тодорхойлсон. Фокус ярилцлагыг боловсруулахдаа нэг чиглэлийн фокус ярилцлагыг 2 хүний бүрэлдэхүүнтэй баг ажиллах ба ярилцлагын агуулга чиглэлийг мөн тодорхойлж, ярилцагчаас өгүүлж болох хариултын хувилбаруудыг аль болох бүрэн дүүрэн тодорхойлох, тэдгээрийг үнэлгээний мэдээлэл болгон кодлох зэргийг тооцож ажиллах чиглэл өгч ажиллав.
- Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээний хүрээнд хичээл ажиглалтыг онолын болон дадлагын хичээл дээр хийхээр төлөвлөлтөд тусгасны дагуу хичээл ажиглалтын хуудас боловсруулах багууд тус бүр 2 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан. Ажиглалтын хуудсыг сайжруулах, нягтлах ажлыг төлөвлөгөөт хугацаанд хийж гүйцэтгэсэн.
- Хяналт, үнэлгээний хуудсаар мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагаас статистик мэдээлэл, тусгай зөвшөөрөл, сургалтын бааз, дотуур байрын орчин, сургалтын хөтөлбөр, төлөвлөлтийн талаарх мэдээллүүдийг авахаар төлөвлөн ажилласан.

1.3.1 Үнэлгээний арга хэрэгслийн найдвартай байдал

Чанарын үнэлгээний судалгаанд боловсруулан ашигласан мэдээлэл цуглуулах арга хэрэгсэлд статистик (Кронбах альфа коэффициент) шинжилгээ хийсэн бөгөөд дараах үр дүнтэй гарсан байна.

Хүснэгт 1. Бичгийн шалгалтын найдвартай байдал

Шалгалтын төрөл	Найдвартай байдлын тоон утга
Суралцагчийн чадамжийн үнэлгээ	0.615
Багшийн чадамжийн үнэлгээ	0.780
Удирдах ажилтны чадамжийн үнэлгээ	0.721

Хүснэгт 2. Асуулга судалгааны найдвартай байдал

Үнэлгээний арга хэрэгсэл	Найдвартай байдлын тоон утга
Суралцагчийн асуулга	0.932
Багшийн асуулга	0.946
Удирдах ажилтны асуулга	0.927
Төгсөгчийн асуулга	0.875
Эцэг, эх, асран хамгаалагчийн асуулга	0.831
Ажил олгогчийн асуулга	0.861

Дээрх 2 хүснэгтээс харахад найдвартай байдлын тоон утга 0.6-аас дээш байгаа нь судалгаанд боловсруулан ашигласан арга хэрэгсэл зорилгоо хангаж чадахуйц болсныг илэрхийлж байна.

1.3.2 Түүврийн хамрах хүрээ, хэмжээг тодорхойлох

Энэхүү үйл ажиллагааны хүрээнд мэдээллийн сан дахь тоон мэдээлэлд тулгуурлан судалгааны олонлог, түүврийн хамрах хүрээ, хэмжээг тодорхойлох ажлыг ерөнхий удирдамж, арга зүйд нийцүүлэн зохион байгууллаа.


Түүврийн эх олонлогийг орон нутгийн 21 аймгийн хэмжээнд 2022-2023 оны хичээлийн жилд сургалтын үйл ажиллагаа явуулж буй сургалтын байгууллагын статистикийн суурь мэдээлэлд үндэслэн тогтоосон.

Чанарын үнэлгээний судалгаанд хамрагдах суралцагчийн түүврийг энгийн санамсаргүй түүврийн аргад үндэслэсэн боловч сургалтын байгууллагаас хамруулах төлөөллийг тэнцүү магадлалтайгаар сонгох тохиолдолд хамгийн бага байх түүврийн хэмжээг дараах томъёогоор тооцож тодорхойлсон. Үүнд:

$$n = \frac{z^2 p(1-p)}{e^2} def f \quad (1)$$

Монгол Улсын 21 аймагт үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын ирүүлсэн статистик мэдээлэлд үндэслэн (1) томъёог ашиглан тооцоолж түүврийг хийсэн.

Түүврийн томъёог ашиглан хийсэн түүвэрт дараах тооны багш, суралцагч, удирдах ажилтнууд сонгогдсон.



1.3.3 Түүврийн хүрэлцээтэй байдал /KMO/

Цуглуулсан чанарын үнэлгээний асуулга судалгаанд фактор шинжилгээ хийж үзэхэд түүврийн хүрэлцээтэй байдлын утга 0.8-аас дээш байгаа нь хүлээн зөвшөөрөгдөх түвшинд буюу мэдээлэлд үндэслэн тайлан боловсруулах боломжтой юм.

Хүснэгт 3. Түүврийн хүрэлцээтэй байдлыг шинжилсэн үр дүн

KMO and Bartlett's Test		Удирдах ажилтан	Багш	Суралцагч	Эцэг эх, асран хамгаалагч	Төгсөгч	Ажил олгогч
Kaiser-Meyer-Olkin Measure of Sampling Adequacy		0.806	0.877	0.966	0.765	0.798	0.844
Bartlett's Test of Sphericity	Approx. Chi-Square	1241.4	4409.5	21377.0	1405.2	639.6	1324.1
	df	351	990	564	325	153	276
	Sig.	<.001	.000	.000	<.001	<.001	<.001

Хүснэгт дэх үр дүнгээс харахад удирдах ажилтнуудын хувьд КМО утга 0.806, багш нарын хувьд КМО утга 0.877, суралцагчдын хувьд КМО утга 0.966, эцэг, эх, асран хамгаалагчийн хувьд КМО утга 0.765, төгсөгчдийн хувьд 0.798, ажилт олгогчийн хувьд КМО утга 0.844 байгаа тул үргэлжлүүлэн статистик шинжилгээ хийх бүрэн боломжтой гэж үзлээ.

ХОЁР. ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын чанарын үнэлгээ зохион байгуулах менежмент


Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын байгууллагын чанарын үнэлгээг менежментийн суурь загвар болох PDCA циклийн дагуу үндсэн 4 үе шатанд хувааж бэлтгэл хангах, зохион байгуулах, үр дүнг боловсруулах, тайлагнах ажлыг хэрэгжүүлсэн байна. Үүнд: (Зураг 4)

Зураг 4. Чанарын үнэлгээ зохион байгуулах менежментийн үе шатууд




Бэлтгэл хангах үе шат нь хэд хэдэн үйл ажиллагааг багтааж байгаа бөгөөд түүнийг нэгтгэн зургаар харууллаа.

Зураг 5. Бэлтгэл хангах үе шатанд хийгддэг үндсэн үйл ажиллагаа



- 1.1 Мэдээллийн сан бүрдүүлэх үйл ажиллагааны хүрээнд Боловсролын ерөнхий газарт үүссэн дата мэдээлэлд суурилан дараах процессын дагуу мэдээллийг бүрдүүлэх, баталгаажуулах ажлыг зохион байгуулсан.

Зураг 6. Мэдээллийн сан бүрдүүлэх, баталгаажуулах үйл ажиллагааны зураглал



Хэдийгээр дээрх процессын дагуу мэдээллийн сангийн бүрдүүлэлт, баталгаажуулах ажлыг хийсэн боловч сургалтын байгууллагын хайхрамжгүй байдлаас шалтгаалан бүрдэл дутуу байх, буруу мэдээлэл илгээх зэрэг асуудал үүсэж байсан. Энэ нь Мэргэжлийн болон техникийн боловсролын салбар дахь тасралтгүй үйл ажиллагаа бүхий нэгдсэн систем зайлшгүй хэрэгцээтэй болохыг харуулж байна.

Зохион байгуулах комисс. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээг Боловсролын үнэлгээний төвөөс томилогдсон комиссын 30 гишүүн орон нутгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын мэргэжилтнүүдтэй хамтран сонгогдсон сургалтын байгууллага дээр зохион байгууллаа. Тухайн сургалтын байгууллага нь энэ удаагийн чанарын үнэлгээнд хамрагдах мэргэжлийн чиглэлээр сургалт эрхэлж байгаа эсэхтэй холбоотойгоор тухайн сургалтын байгууллага дээр бичгийн болон ур чадварын шалгалттай эсэхээс хамааран 1-2 хүний бүрэлдэхүүнтэй баг ажилласан болно.

Шалгалт судалгааны хуваарь: Бичгийн шалгалтыг Улаанбаатарын цагаар нэгэн зэрэг дараах хуваариар зохион байгууллаа.

Хүснэгт 4. Чанарын үнэлгээ зохион байгуулах хуваарь


№	Үйл ажиллагаа	Сар, өдөр	Эхлэх цаг
1	Суралцагчдын бичгийн шалгалт	2023.03.28	09:00
2	Удирдах ажилтан болон багшийн бичгийн шалгалт, онлайн асуулга	2023.03.28	14:00
3	Суралцагчдын ур чадварын үнэлгээ	2023.03.29	10:00
4	Чанарын үнэлгээний арга хэрэгслээр мэдээлэл цуглуулах	2023.03.27-30	

Үнэлгээний мэдээлэл цуглуулах үйл явц. Энэ удаагийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээг цахим технологид суурилж үнэлгээний мэдээлэл цуглуулахыг зорьсон бөгөөд бичгийн шалгалтыг орон нутагт цаасан суурьтай авч үр дүнг цуглуулсан. Мөн суралцагчийн, багшийн, удирдах ажилтны, эцэг эхийн, ажил олгогчийн, төгсөгчийн асуулга судалгаа, фокус ярилцлага, дадлагын хичээл ажиглалт, ур чадварын шалгалтын үр дүнг Боловсролын үнэлгээний төвийн asuulga.eec.mn портал сайтад шивүүлж үнэлгээний мэдээллийг бүрдүүлж авлаа.

Боловсролын үнэлгээний төвөөс томилогдсон комиссоос гадна бичгийн шалгалттай сургалтын байгууллагууд дээр үнэлгээний ажилтантай гэрээлж ур чадварын шалгалт болон хичээл ажиглалтыг хөтлөн явуулсан болно.

Үр дүнг боловсруулах үйл ажиллагааг дараах зураглалын дагуу зохион байгууллаа. Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын чанарын судалгаа, үнэлгээний үр дүнг цуглуулах, нэгтгэх, хэлбэржүүлэх түүнийг боловсруулах үйл ажиллагааг дараах зураглал /зураг/-ын дагуу зохион байгуулж, мэдээллийн сан бүрдүүлнэ.


Зураг 7. Өгөгдөл, мэдээлэл цуглуулах, боловсруулах менежментийн зураглал



Зураглалын дагуу мэдээлэл цуглуулснаар нэгтгэх, хэлбэржүүлэх, боловсруулалт хийх, **BI tableau** системд байршуулах үйл ажиллагаа зохион байгуулагдсан.

Мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийх боломжийг бий болгосноор тайлан боловсруулах үе шат эхлэх бөгөөд дараах зураглалын дагуу боловсруулалтын ажил хийгдсэн байна.

Зураг 8. Дэлгэрэнгүй тайлан, зөвлөмж боловсруулах үйл ажиллагааны дараалал



Цуглуулсан мэдээлэлд Microsoft office болон статистик шинжилгээний SPSS 25 программыг ашиглан боловсруулалт хийж дэлгэрэнгүй тайланг гаргалаа.


ГУРАВ. ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ СУДАЛГААНЫ ЕРӨНХИЙ ҮР ДҮН

3.1 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагчдаас авсан шалгалтын ерөнхий үр дүн

Аймаг, орон нутагт үйл ажиллагаа явуулж буй сургалтын байгууллагын суралцагчдаас авсан бичгийн шалгалтад 33 сургалтын байгууллагын 1.429 суралцагч хамрагдсан бөгөөд гүйцэтгэлийн дундаж **66.2** хувьтай үнэлэгдсэн байна.

Суралцагчдаас авсан 8 мэргэжлийн хөтөлбөрийн бичгийн шалгалтад хамрагдсан нийт суралцагчдын 35.9 хувь нь эмэгтэй, 64.1 хувь нь эрэгтэй суралцагчид байна.

Суралцагчдын сурлагын амжилтыг харьцуулсан үр дүнгээс харахад эрэгтэй суралцагчид 64.9 хувь, эмэгтэй суралцагчид 68.5 хувьтай үнэлэгдсэн байна.



Судалгаанд хамрагдсан суралцагчдыг сургалтын байгууллагын ангиллаар авч үзвэл мэргэжлийн боловсролын сургуулиас 31.7 хувь, политехник коллежоос 68.3 хувь нь хамрагдсан байна. Тэдгээрийн үр дүнг дараах хүснэгтэд нэгтгэн харууллаа.

Хүснэгт 5. Байгууллагын ангиллаар харьцуулсан үр дүн, гүйцэтгэлийн хувиар

№	Байгууллагын ангилал/статус	Орон нутгийн сургалтын байгууллагын хэв шинжээс хамаарсан дундаж хувь	Хүйс /хувиар/	
			эрэгтэй	эмэгтэй
1	Мэргэжлийн боловсролын сургууль	64.3	63.1	66.3
2	Политехник коллеж	67.0	65.6	69.6

Байгууллагын статусаар харьцуулсан үр дүнгээс харахад мэргэжлийн боловсролын сургуулийн суралцагчдын үр дүн 64.3 хувь, политехник коллежид суралцаж буй суралцагчид 67.0 хувьтай үнэлэгдсэн байна. Мөн хүйсээр харьцуулсан үр дүнгээс харахад эмэгтэй суралцагчид эрэгтэй суралцагчдаас 3.2-4.0 хувиар дээгүүр үзүүлэлттэй шалгагдсан байна.

Суралцагчдаас авсан чанарын үнэлгээний бичгийн шалгалтын үр дүнг сургалтын байгууллагын өмчийн хэлбэрээр дэлгэрүүлэн шинжилж үзэхэд төрийн өмчийн болон төрийн бус өмчийн сургалтын байгууллагын суралцагчдын хувьд гүйцэтгэлийн зөрүү маш бага байгаа боловч хүйсээр харьцуулсан үр дүнгээс харахад өгсөн даалгаврыг эмэгтэй суралцагчид эрэгтэй суралцагчдаас 1.3-3.7 хувь дээгүүр гүйцэтгэсэн байгааг хүснэгт дэх дэлгэрэнгүй мэдээллээс харж болно.


Хүснэгт 6. Сургалтын байгууллагын өмчийн хэлбэр болон хүйсээр харьцуулсан үр дүн, гүйцэтгэлийн хувиар

Сургалтын байгууллагын өмчийн хэлбэр	Гүйцэтгэлийн дундаж хувь	Хүйс /хувиар/	
		эрэгтэй	эмэгтэй
Төрийн өмчийн	64.5	64.9	68.6
Төрийн бус өмчийн	66.2	65.0	63.7

Өмчийн хэлбэрээр харьцуулахаас гадна сургалтын байгууллагын байршлаар харьцуулсан үр дүнг дор харуулсан байна. Чанарын үнэлгээний судалгаанд хамрагдсан сургалтын байгууллагуудыг газар зүйн бүсээр 4 ангилан үр дүнг харьцуулсан мэдээллийг графикаас харж болно.

Нийт сургалтын байгууллагын 18.2 хувь нь Баруун бүсэд, 15.2 хувь нь Зүүн бүсэд, 24.2 хувь нь Хангайн бүсэд, 41.4 хувь нь Төвийн бүсэд хамаарч байна.

Зураг 9. Газар зүйн бүсээр харьцуулсан үр дүн, гүйцэтгэлийн хувиар



Бүсээр харьцуулсан үр дүнгээс харахад Хангайн бүсийн сургалтын байгууллагуудын гүйцэтгэлийн дундаж 69 хувь байгаа бол Баруун, Зүүн бүс тус бүр 66.7 хувь, Төвийн бүс 64 хувьтай үнэлэгдсэн байна.

Мөн сургалтын байгууллагуудыг аймгийн төв, сумын төв гэсэн ангиллаар харьцуулан судалсан бөгөөд нийт сургуулиудын 79 хувь нь аймгийн төвд, 21 хувь нь сумын төвд үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 7. Сургалтын байгууллагын байршлаас хамаарсан үр дүн, гүйцэтгэлийн хувиар

Сургалтын байгууллагын байршил	Гүйцэтгэлийн хувь
Аймгийн төв	66.6
Сумын төв	63.4

Хүснэгт дэх мэдээллээс харахад аймгийн төвийн сургуулиудын үр дүн 66.6 хувь, сумын төвийн сургуулиуд 63.4 хувьтай үнэлэгдсэн байна.

Суралцагчдаас авсан бичгийн шалгалт нь **онолын** болон **ур чадварын** гэсэн 2 төрлөөр зохион байгуулагдсан бөгөөд онолын шалгалт нь сонгох хэлбэрийн 24 тест даалгавартайгаар, ур чадварын даалгаврууд нь чадамжийн нэгж дэх эзэмшвэл зохих гол чадамжийг үнэлэхээр боловсруулагдсан байна. Шалгалтын төрлөөр гүйцэтгэлийн дундаж болон хүйсээр харьцуулсан үр дүнг доор хүснэгтэд нэгтгэсэн байна.

Хүснэгт 8. Шалгалтын төрлөөр болон хүйсээр харьцуулсан үр дүн, гүйцэтгэлийн хувиар

Шалгалтын төрөл	Улсын дундаж	Хүйс /хувиар/	
		эрэгтэй	эмэгтэй
Онолын шалгалт	40.3	38.5	43.3
Ур чадварын шалгалт	92.1	91.2	93.7


Үр дүнгээс, суралцагчид онолын мэдлэг, чадварыг шалгасан даалгавруудыг 40.3 хувьтай гүйцэтгэсэн бол ур чадварын шалгалтыг 92.1 хувьтай гүйцэтгэсэн байна. Мөн хүйсээр харьцуулсан үр дүнгээр эмэгтэй суралцагчид онолын болон ур чадварын шалгалтыг эрэгтэй суралцагчдаас 2.5-4.8 хувиар илүү гүйцэтгэсэн үзүүлэлттэй байна.

Сонгогдсон мэргэжлийн хөтөлбөрийн хүрээнд суралцагчдын онолын мэдлэг, чадварыг үнэлэх даалгаврыг Блумын таксаномийн танин мэдэхүйн 4 түвшинд харгалзуулан хөтөлбөр тус бүрээр 24 даалгавартай нийт 50 онооны сорилын материалыг боловсруулж бэлтгэсэн.

Танин мэдэхүйн түвшин тус бүрд харгалзах даалгаврын эзлэх хувийг ойролцоогоор:

Зураг 10. Суралцагчдаас авсан бичгийн шалгалт дахь танин мэдэхүйн түвшний харьцаа

Онолын шалгалтын материал дахь танин мэдэхүйн түвшний эзлэх хувь



Энэхүү танин мэдэхүйн түвшин тус бүрд харгалзах даалгаврын гүйцэтгэлийг авч үзэхэд практиктай холбосон буюу хэрэглээний даалгаврын гүйцэтгэл 48.5 хувьтай байгаа бол үнэлэх, чадвар шалгасан даалгавруудын гүйцэтгэл 41.6-42.4 хувьтай байна.

Хүснэгт 9. Танин мэдэхүйн түвшин болон хүйсээр харьцуулсан үр дүн, гүйцэтгэлийн хувиар /онолын шалгалтаар/


Танин мэдэхүйн түвшин	Орон нутгийн дундаж хувь	Хүйс /хувиар/	
		эрэгтэй	эмэгтэй
Мэдлэг	45.0	44.0	46.8
Ойлголт	40.6	37.0	46.9
Хэрэглэх	44.7	44.8	44.5
Үнэлэх	37.1	27.1	37.1

Танин мэдэхүйн түвшний даалгавруудын гүйцэтгэлийг хүйсээр харьцуулсан дүнгээс харахад эрэгтэй, эмэгтэй суралцагчдын мэдлэг, ойлголтын түвшний даалгаврын гүйцэтгэлийн хувь ойролцоо байгаа бол бусад түвшний даалгавруудын хувьд эмэгтэй суралцагчдын гүйцэтгэл эрэгтэй суралцагчид болон улсын дунджаас дээгүүр үзүүлэлттэй байна.

Даалгавруудыг танин мэдэхүйн түвшнээр нь ангилж үр дүнг сургалтын байгууллагын байршил, мэргэжлийн хөтөлбөр, хүйсээс хамаарсан байдлыг харьцуулан судаллаа.

Аймгийн төв болон сумын төвд байрлан сургалт, үйл ажиллагаа явуулж буй сургуулиудын суралцагчдын онолын мэдлэг, чадварыг үнэлсэн даалгаврын гүйцэтгэлийг танин мэдэхүйн түвшнээр задалж үр дүнг харьцуулсан графикийг доор харууллаа.

Зураг 11. Танин мэдэхүйн түвшин болон сургалтын байгууллагын байршлаас хамаарсан үр дүн, гүйцэтгэлийн хувиар




Графикаас харахад нийтлэг байдлаараа аймгийн төвийн сургалтын байгууллагын суралцагчид сумын төвийн сургалтын байгууллагын суралцагчдаас 1.5-4.8 хувийн зөрүүтэй гүйцэтгэсэн байна. Мөн аймгийн төвийн сургалтын байгууллагын суралцагчид сэргээн санах, хэрэглэх түвшний даалгавруудыг 45 орчим хувьтай гүйцэтгэсэн бол үнэлэх түвшний даалгаврын гүйцэтгэл хамгийн бага буюу 31.1 хувьтай үнэлэгдсэн байна.

Харин сумын төвийн сургалтын байгууллагад суралцаж буй суралцагчдын хувь сэргээн санах, хэрэглэх түвшний даалгавруудыг 40 орчим хувьтай гүйцэтгэсэн бол үнэлэх түвшний даалгаврыг 29.7 хувьтай гүйцэтгэсэн байна.

Судалгаанд хамрагдсан сургалтын байгууллагын суралцагчдын хүйс болон танин мэдэхүйн түвшний хооронд хамаарал байгаа эсэхийг судалж үзэхэд эмэгтэй суралцагчид эрэгтэй суралцагчдаас 2.8-10.0 хувиар илүү гүйцэтгэсэн үзүүлэлттэй байна. Дэлгэрэнгүй мэдээллийг зураг 12 -оос харна уу.


Зураг 12. Танин мэдэхүйн түвшин болон суралцагчдын хүйсээр харьцуулсан үр дүн, гүйцэтгэлийн хувиар



Дээрх зургаас харахад сэргээн санах, хэрэглэх түвшний даалгавруудыг 44 орчим хувьтай гүйцэтгэсэн байгаа бол эмэгтэй суралцагчид ойлгох түвшний даалгаврыг 46.9 хувьтай гүйцэтгэсэн байна. Харин үнэлэх түвшинд эрэгтэй, эмэгтэй суралцагчид 40-өөс доош хувьтай гүйцэтгэсэн байна.

Сургалтын байгууллагын өмчийн хэлбэрээс хамааруулан суралцагчдын танин мэдэхүйн даалгавруудын гүйцэтгэлд шинжилгээ хийхэд төрийн өмчийн сургуулиудын суралцагчид төрийн бус өмчийн сургалтын байгууллагын суралцагчдаас 1.6-11.2 хувиар илүү гүйцэтгэлтэй шалгагдсан байна.

Зураг 13. Сургалтын байгууллагын өмчийн хэлбэр болон суралцагчдын танин мэдэхүй түвшний даалгаврын гүйцэтгэлийг харьцуулсан үр дүн



Хүснэгт 10. Онолын шалгалт болон хүйсээр харьцуулсан үр дүн, гүйцэтгэлийн хувиар

Шалгалтын төрөл	Улсын дундаж	Хүйс /хувиар/	
		эрэгтэй	эмэгтэй
Автомашины засварчин	35.2	35.0	37.7
Сантехникч	38.0	38.1	35.0
Барилгын цахилгаанчин	51.0	50.9	51.9
Гагнуурчин	25.1	25.1	24.9
Засал чимэглэл	46.7	47.1	46.0
Оёдол	41.7	33.1	42.3
Тогооч	43.6	43.6	43.7
Үсчин	40.4	36.0	41.6


Хүснэгт 11. Ур чадварын шалгалт болон хүйсээр харьцуулсан үр дүн, гүйцэтгэлийн хувиар

Шалгалтын төрөл	Улсын дундаж	Хүйсээр	
		эрэгтэй	эмэгтэй
Автомашины засварчин	90.3	90.4	89.2
Сантехникч	95.9	95.8	100.0
Барилгын цахилгаанчин	90.4	90.9	87.9
Гагнуурчин	89.0	88.8	92.2
Засал чимэглэл	92.4	91.6	93.8
Оёдол	95.8	94.9	95.9
Тогооч	90.9	90.9	90.8
Үсчин	96.5	94.9	97.0

Чадамжийн хөтөлбөрүүдийг хүйсээр харьцуулахаас гадна шалгалтын төрлөөр харьцуулан дүн шинжилгээ хийх боломжтой юм. Доорх графикаас

Зураг 14. Чадамжийн хөтөлбөр болон шалгалтын төрлөөр харьцуулсан үр дүн, хувиар

Гүйцэтгэлийн дундаж, шалгалтын төрлөөр харьцуулсан үр дүн, хувиар



Сонгогдсон мэргэжлийн хөтөлбөрийн хүрээнд боловсруулсан **ОНОЛЫН** шалгалтын материал дахь даалгавруудыг танин мэдэхүйн 4 түвшинд ангилж гүйцэтгэлийн үр дүнг дараах хүснэгтэд нэгтгэлээ.

Хүснэгт 12. Мэргэжлийн хөтөлбөр болон танин мэдэхүйн түвшнээр харьцуулсан үр дүн

Мэргэжлийн хөтөлбөр	Танин мэдэхүйн түвшин			
	Сэргээн санах	Ойлгох	Хэрэглэх	Үнэлэх
Автомашинь засварчин	47.9	34.2	44.1	22.6
Сантехникч	52.6	38.6	48.5	22.9
Барилгын цахилгаанчин	54.8	49.1	46.9	
Гагнуурчин	26.5	29.1	38.0	10.0
Засал чимэглэл	44.2	33.9	50.7	54.0
Оёдол	45.5	60.9	38.0	29.0
Тогооч	53.1	41.4	44.3	41.5
Үсчин	36.4	36.7	54.0	33.4

Хүснэгт 13. Сургалтын байгууллагын ерөнхий үр дүн болон шалгалтын төрлөөр харьцуулсан үр дүн

Аймгийн нэр	Сургалтын байгууллагын дундаж	Шалгалтын төрлөөр, гүйцэтгэлийн хувиар	
		Онолын шалгалтын үр дүн	Ур чадварын шалгалтын үр дүн
Архангай аймаг	63.8	32.9	94.7
Баян-Өлгий аймаг	61.6	32.3	90.8
Баянхонгор аймаг	72.5	47.3	97.8
Булган аймаг	55.2	23.3	87.2
Говь-Алтай аймаг	69.9	43.6	96.2
Говьсүмбэр аймаг	65.3	39.3	91.4
Дархан-Уул аймаг	64.7	38.9	90.5
Дорноговь аймаг	69.2	48.3	90.1
Дорнод аймаг	67.6	41.5	93.7
Дундговь аймаг	63.4	40.3	86.6
Завхан аймаг	71.7	47.8	95.5
Орхон аймаг	65.2	39.7	90.8
Өвөрхангай аймаг	72.9	48.9	96.8
Өмнөговь аймаг	63.9	39.3	88.5
Сүхбаатар аймаг	65.5	37.9	93.1
Сэлэнгэ аймаг	62.6	32.0	93.3
Төв аймаг	60.2	33.8	86.6
Увс аймаг	67.5	39.1	95.9
Ховд аймаг	66.5	38.6	94.4
Хөвсгөл аймаг	66.6	41.3	92.0
Хэнтий аймаг	65.7	44.1	87.3

Сургалтын байгууллага тус бүрийг харьцуулсан үр дүнгээс харахад сургалтын байгууллагын ерөнхий дундаж гүйцэтгэлээрээ Өвөрхангай аймаг дахь политехник

коллежийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж 72.9 хувийн үзүүлэлттэй байгаа бол Сүхбаатар аймаг дахь мэргэжлийн боловсролын сургуулийн суралцагчдын гүйцэтгэл 65.5 хувийн үзүүлэлттэй шалгагдсан байна.


Сургалтын байгууллагын ерөнхий гүйцэтгэлийг шалгалтын төрлөөр харьцуулсан үр дүнгээс харахад онолын шалгалтаар Завхан аймаг дахь политехник коллеж 49.2 хувийн үзүүлэлттэй байгаа бол ур чадварын үнэлгээгээр Завхан аймгийн Тосонцэнгэл суман дахь мэргэжлийн боловсролын сургууль 100 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

3.2 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын удирдах ажилтнаас авсан шалгалтын ерөнхий үр дүн

Энэ удаагийн чанарын үнэлгээний судалгаанд удирдах ажилтнуудын монгол хэл бичиг, цахим ур чадвар, болон эрх зүйн мэдлэг, ойлголт, чадварыг үнэлэх зорилгоор сонгох хэлбэрийн 58 тест даалгавар боловсруулан компьютерт суурилсан хэлбэрээр үнэлгээг зохион байгууллаа.

Зураг 15. Агуулгын хүрээ, даалгаврын эзлэх хувь

Удирдах ажилтнуудаас авсан шалгалтын материал дахь агуулгын эзлэх хувь




Дээрх 3 агуулгын хүрээнд нийт 63 удирдах ажилтан үнэлгээнд хамрагдсан бөгөөд шалгалтын үр дүн 66.7 хувьтай гарсан байна.

Удирдах ажилтнуудыг сургалтын байгууллагын өмчийн хэлбэрээр нь ангилан үр дүнг харьцуулахад төрийн өмчийн сургалтын байгууллагын удирдах ажилтнуудын гүйцэтгэлийн дундаж 67.7 хувьтай, төрийн бус өмчийн сургалтын байгууллагын удирдах ажилтнуудын гүйцэтгэлийн дундаж 54.8 хувьтай байна.

Мөн шалгалтын үр дүнг агуулгын 3 чиглэлээр задлан авч үзвэл хууль эрх зүйн мэдлэгийг шалгасан даалгавруудын гүйцэтгэл 75.45 хувь, монгол хэл бичгийн мэдлэг, ойлголтыг шалгасан даалгавруудын гүйцэтгэл 66.43 хувь, цахим ур чадварын үнэлгээний даалгавруудын гүйцэтгэл 58.38 хувьтай үнэлэгдсэн байна.


Зураг 16. Удирдах ажилтнаас авсан шалгалтын үр дүн



Удирдах ажилтнуудын мэдлэг, чадварын үнэлгээний үр дүн сургалтын байгууллагын ангиллаас хэрхэн хамаарч байгааг судалсан дүнгээр мэргэжлийн боловсролын сургуулийн удирдах ажилтнуудын үнэлгээ 67.0 хувь, политехник коллежийн удирдах ажилтнуудын үнэлгээ 66.5 хувьтай гарсан байна.

Судалгаанд хамрагдсан удирдах ажилтнуудын хүйсээс хамаарсан судалгааг хийж харьцуулахад 54.3 хувь нь эмэгтэй, 45,7 хувь нь эрэгтэй албан хаагчид хамрагдсан байна.

Зураг 17. Удирдах ажилтнаас авсан шалгалтын үр дүнг хүйсээр харьцуулсан шинжилгээ




Удирдах ажилтнуудын хүйсээс хамаарсан чадамжийн үнэлгээний үр дүнг авч үзвэл эмэгтэй албан хаагчдын гүйцэтгэлийн дундаж 66.2 хувь, эрэгтэй албан хаагчдын гүйцэтгэлийн дундаж 67.4 хувьтай гарсан байна.

Үнэлгээнд хамрагдсан сургуулиудын удирдах ажилтнуудыг ажилласан жилээр нь авч үзвэл 14,3 хувь нь эхний жилдээ, 41,4 хувь нь 1-5 жил, 31,4 хувь нь 6-10 жил, 7,1 хувь нь 11-

15 жил, 4.3 хувь нь 16-20 жил, 1.4 хувь нь 21-с дээш жил ажилласан мэдээлэл бүртгэгдсэн байна. Тэдний чадамжийн үнэлгээний үр дүнг харьцуулан харууллаа.


Зураг 18. Удирдах ажилтнуудын ажилласан жил ба чадамжийн үнэлгээний үр дүн



Зураг 17-оос харахад 1-5 жил ажиллаж буй удирдах ажилтнуудын чадамжийн үнэлгээ 68,4 хувь байгаа бол 21-с дээш жил ажиллаж байгаа удирдах ажилтнуудын чадамжийн үнэлгээ 53.0 хувьтай байна.

Зураг 19. Удирдах ажилтнуудын чадамжийн үнэлгээний үр дүн, аймгаар

Удирдах ажилтнуудын чадамжийн үнэлгээний үр дүн, аймгаар, эзлэх хувиар



Удирдах ажилтнуудын чадамжийн үнэлгээний үр дүнг харьяалагдах аймаг тус бүрээр дэлгэрэнгүй үзүүлэлтийг гарган харьцуулахад Дундговь аймгийн удирдах ажилтнуудын

чадамжийн үнэлгээ 78.8 хувьтай үнэлэгдсэн бол Баянхонгор аймгийн удирдах ажилтнуудын чадамж 57.6 хувийн үзүүлэлтэй үнэлэгдсэн байна.

Аймгийн хэмжээний үр дүнг нарийвчлан сургалтын байгууллагын дундаж болон агуулга тус бүрээр үр дүнг дэлгэрүүлэн дараах хүснэгтээр нэгтгэн харууллаа. Үүнд:

Хүснэгт 14. Удирдах ажилтны чадамжийн үнэлгээний үр дүн, сургалтын байгууллага, агуулгаар

Сургалтын байгууллагын нэр	Сургалтын байгууллагын дундаж	Монгол хэл бичиг	Хууль эрх зүй	Цахим ур чадвар
Архангай аймаг дахь Булган мэргэжлийн боловсролын сургууль	58.3	63.6	56.8	54.5
Баян-Өлгий аймаг дахь мэргэжлийн боловсролын сургууль	60.6	54.5	79.5	47.7
Баянхонгор аймаг дахь Өлзийт мэргэжлийн боловсролын сургууль	47.7	38.6	63.6	40.9
Баянхонгор аймаг дахь политехник коллеж	67.4	68.2	65.9	68.2
Булган аймаг дахь мэргэжлийн боловсролын сургууль	70.5	70.5	81.8	59.1
Булган аймаг дахь ХАА-н мэргэжлийн боловсролын сургууль	68.2	68.2	81.8	54.5
Говь-Алтай аймаг дахь мэргэжлийн боловсролын сургууль	63.6	63.6	79.5	47.7
Говьсүмбэр аймаг дахь политехник коллеж	69.7	70.5	75.0	63.6
Дабль фиш ХХК-ийн дэргэдэх мэргэжлийн боловсролын сургууль	62.1	59.1	63.6	63.6
Дархан-Уул аймаг дахь Дархан Өргөө политехник коллеж	68.2	72.7	75.0	56.8
Дархан-Уул аймаг дахь Политехник коллеж	68.2	70.5	72.7	61.4
Дархан-Уул аймаг дахь Уул уурхай эрчим хүчний политехник коллеж	51.5	47.7	59.1	47.7
Дорноговь аймаг дахь политехник коллеж	72.0	84.1	72.7	59.1
Дорнод аймаг дахь мэргэжлийн боловсролын сургууль	69.7	40.9	95.5	72.7
Дорнод аймаг дахь политехник коллеж	69.7	63.6	86.4	59.1
Дундговь аймаг дахь политехник коллеж	78.8	81.8	88.6	65.9
Завхан аймаг дахь политехник коллеж	78.0	79.5	88.6	65.9
Завхан аймгийн Тосонцэнгэл суман дахь мэргэжлийн боловсролын сургууль	72.7	70.5	79.5	68.2
Орхон аймаг дахь мэргэжлийн боловсролын сургууль	74.2	70.5	84.1	68.2
Орхон аймаг дахь ХАА-н мэргэжлийн боловсролын сургууль	64.4	68.2	61.4	63.6
Өвөрхангай аймаг дахь политехник Коллеж	76.5	86.4	81.8	61.4
Өмнөговь аймаг дахь политехник коллеж	71.2	75.0	72.7	65.9
Сүхбаатар аймаг дахь мэргэжлийн боловсролын сургууль	74.2	75.0	84.1	63.6
Сэлэнгэ аймаг дахь Зүүнхараа политехник коллеж	65.2	68.2	68.2	59.1

Сэлэнгэ аймаг дахь мэргэжлийн боловсролын сургууль	75.8	75.0	88.6	63.6
Сэлэнгэ аймгийн Шаамар суман дахь мэргэжлийн боловсролын сургууль	64.4	63.6	72.7	56.8
Төв аймаг дахь политехник Коллеж	53.8	52.3	63.6	45.5
Төв, Баянчандмань суман дахь политехник коллеж	71.2	72.7	79.5	61.4
Төв аймгийн Заамар суман дахь мэргэжлийн боловсролын сургууль	65.9	70.5	72.7	54.5
Төв аймгийн Эрдэнэ суман дахь мэргэжлийн боловсролын сургууль	72.0	70.5	79.5	65.9
Увс аймаг дахь Улаангом политехник коллеж	63.6	54.5	77.3	59.1
Ховд аймаг дахь Хөгжил политехник коллеж	62.1	45.5	86.4	54.5
Хөвсгөл аймаг дахь политехник коллеж	63.6	65.9	72.7	52.3
Хэнтий аймаг дахь политехник коллеж	51.5	50.0	54.5	50.0
Хэнтий аймгийн Бор-Өндөр суман дахь мэргэжлийн боловсролын сургууль	65.2	75.0	75.0	45.5
Эрдэнэт цогцолбор дээд сургуулийн харьяа политехник коллеж	70.5	68.2	79.5	63.6

Хүснэгт дэх мэдээллээс сургалтын байгууллага тус бүрээс хамрагдсан удирдах ажилтнуудын амжилтыг агуулгаар харьцуулан үзэхэд:


- ✓ Сургалтын байгууллагын ерөнхий гүйцэтгэлийн дундаж үзүүлэлтээр Дундговь аймаг дахь политехник коллеж 78.8 хувьтай үнэлэгдсэн бол Баянхонгор аймаг дахь Өлзийт мэргэжлийн боловсролын сургуулийн гүйцэтгэлийн дундаж 50.8 хувийн үр дүнтэй гарсан байна.
- ✓ Монгол хэл бичгийн шалгалтын үр дүнгээр Өвөрхангай аймаг дахь политехник коллежийн удирдах ажилтнууд 86.4 хувийн амжилтаар бусад сургалтын байгууллагаас дээгүүр үнэлгээтэй байгаа бол Баянхонгор аймаг дахь Өлзийт мэргэжлийн боловсролын сургуулийн удирдах ажилтнуудын гүйцэтгэл 38.6 хувийн үр дүнтэй үнэлэгдсэн байна.
- ✓ Хууль, эрх зүйн мэдлэг, ойлголтыг шалгасан даалгаврын гүйцэтгэлээр Дорнод аймаг дахь мэргэжлийн боловсролын сургуулийн удирдлагууд 95.5 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн бол Хэнтий аймаг дахь политехник коллежийн удирдлагууд 54.5 хувьтай үнэлэгдсэн байна.
- ✓ Цахим ур чадварыг шалгасан даалгавруудын гүйцэтгэлээр Дорнод аймаг дахь мэргэжлийн боловсролын сургуулийн удирдлагууд 72.7 хувьтай үнэлэгдсэн бол Баянхонгор аймаг дахь Өлзийт мэргэжлийн боловсролын сургуулийн багш нар 40.9 хувьтай байна.

3.3 Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нараас авсан шалгалтын ерөнхий үр дүн

Энэхүү чанарын үнэлгээний судалгаанд мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нараас сонгон нийт 183 багшаас монгол хэл бичиг, хууль эрх зүйн мэдлэг, ойлголт, цахим ур чадвар гэсэн 3 чиглэлээр сонгох хэлбэрийн 58 тест даалгавар боловсруулан үнэлгээ хийлээ.

Зураг 20. Агуулгын хүрээ, даалгаврын эзлэх хувь

Багш нараас авсан шалгалтын материал дахь агуулгын харьцаа



■ Монгол хэл, бичиг ■ Эрх зүйн мэдлэг ■ Цахим ур чадвар


Гурван агуулгын хүрээнд удирдах ажилтнаас авсан шалгалтын үр дүн 56.08 хувьтай гарсан байна.

Харин сургалтын байгууллагын өмчийн хэлбэрээр ангилсан үр дүнгээр төрийн өмчийн сургалтын байгууллагуудын багш нарын гүйцэтгэлийн дундаж 55.7 хувь, төрийн бус өмчийн сургалтын байгууллагуудын багш нарын дундаж 59,9 хувьтай байна.


Мөн шалгалтын үр дүнг агуулгын 3 чиглэлээр авч үзвэл хууль эрх зүйн мэдлэгийг шалгасан даалгавруудын гүйцэтгэл 55.7 хувь, монгол хэл бичгийн мэдлэг, ойлголтыг шалгасан даалгавруудын гүйцэтгэл 60.8 хувь, цахим ур чадварын үнэлгээний даалгавруудын гүйцэтгэл 50.4 хувьтай үнэлэгдсэн байна.

Зураг 21. Агуулга тус бүрийн гүйцэтгэлийн дундаж хувь

Багш нараас авсан шалгалтын агуулга тус бүрийн үр дүн, хувиар



Зураг 22. Сургалтын байгууллагын байршил болон багш нарын чадамжийн үнэлгээний үр дүнгийн хамаарал



Багшийн чадамжийн үнэлгээний үр дүнг сургалтын байгууллагын байршлаас хамаарч байгаа эсэхийг судалсан дүнгээс харахад аймгийн төвийн сургалтын байгууллагын багш нарын гүйцэтгэлийн дундаж 56.4 хувь, сумын төвийн сургалтын байгууллагын багш нарын гүйцэтгэлийн дундаж 54.9 хувийн үзүүлэлттэй байна.

Мөн багш нарын үнэлгээний үр дүнг сургалтын байгууллагын хэв шинжээр дэлгэрүүлэн судалж үзэхэд мэргэжлийн боловсролын сургуулийн багш нарын үнэлгээ 55.7 хувь, политехник коллежийн багш нарын үнэлгээ 59.9 хувьтай гарсан байна.

Багш нарыг боловсролын түвшнээр нь харьцуулахад нийт багш нарын 41.0 хувь нь магистр зэрэгтэй, 41.5 хувь нь бакалавр, 17.5 хувь нь дипломын боловсролтой хэмээн хариулсан байна. Тэдгээр багш нарын чадамжийн үнэлгээний үр дүнг нэгтгэн харууллаа.


Зураг 23. Боловсролын түвшин болон багшийн чадамжийн үнэлгээний үр дүн, гүйцэтгэлийн хувиар



Мөн судалгаанд хамрагдсан багш нарыг албан тушаалаар нь ангилсан дүнгээс харахад 18.0 хувь нь мастер багш, 55.2 хувь нь багш, 15.8 хувь нь ахлах багш, 10.9 хувь нь дадлагажигч багш байна. Тэдгээр багш нарын чадамжийн үнэлгээний үр дүнг харьцуулан судлахад:

Зураг 24. Багшийн мэргэжлийн зэрэг болон чадамжийн үнэлгээний үр дүн

Багш нарын албан тушаалын ангилал болон чадамжийн үнэлгээний үр дүн, гүйцэтгэлийн хувиар




Дээрх дүнгээс харахад мастер багш нарын гүйцэтгэлийн дундаж 61 хувь, ахлах багш нарын гүйцэтгэлийн дундаж 54.2 хувь, багш нарын гүйцэтгэлийн дундаж 55.8 хувь байгаа бол дадлагажигч багш нарын гүйцэтгэлийн дундаж 52 хувьтай гарсан байна.

Багшийн чадамжийн үнэлгээний үр дүнг харьяалагдах аймаг тус бүрээр дэлгэрэнгүй үзүүлэлтийг гаргах харьцуулахад Өвөрхангай аймгийн багш нарын чадамжийн үнэлгээ 74.4 хувьтай үнэлэгдсэн бол Баян-Өлгий аймгийн багш нарын чадамж 32.9 хувийн үзүүлэлтэй үнэлэгдсэн байна.

Зураг 25. Багшийн чадамжийн үнэлгээний үр дүн, аймгаар

Багшийн чадамжийн үнэлгээний үр дүн, аймгаар, эзлэх хувиар



Аймгийн хэмжээний үр дүнг нарийвчлан сургалтын байгууллагын дундаж болон агуулга тус бүрээр үр дүнг дэлгэрүүлэн дараах хүснэгтээр нэгтгэн харууллаа. Үүнд:

Хүснэгт 15. Багшийн чадамжийн үнэлгээний үр дүн, сургалтын байгууллага, агуулгаар

Сургалтын байгууллагын нэр	Сургалтын байгууллагын дундаж	Монгол хэл бичиг	Хууль эрх зүй	Цахим ур чадвар
Архангай аймаг дахь Булган мэргэжлийн боловсролын сургууль	56.8	71.4	53.3	40.9
Баян-Өлгий аймаг дахь мэргэжлийн боловсролын сургууль	32.9	26.4	34.4	40.0
Баянхонгор аймаг дахь Өлзийт мэргэжлийн боловсролын сургууль	50.6	50.7	57.8	44.5
Баянхонгор аймаг дахь политехник коллеж	55.0	58.6	53.3	51.8
Булган аймаг дахь мэргэжлийн боловсролын сургууль	57.4	61.4	53.3	55.5
Булган аймаг дахь ХАА-н мэргэжлийн боловсролын сургууль	60.9	61.4	71.1	51.8
Говь-Алтай аймаг дахь мэргэжлийн боловсролын сургууль	64.4	67.1	72.2	54.5
Говьсүмбэр аймаг дахь политехник коллеж	55.3	63.6	43.3	54.5
Дабль фиш ХХК-ийн дэргэдэх мэргэжлийн боловсролын сургууль	63.8	65.7	62.2	62.7
Дархан-Уул аймаг дахь Дархан Өргөө политехник коллеж	58.8	67.1	65.6	42.7
Дархан-Уул аймаг дахь политехник коллеж	45.9	45.0	46.7	46.4
Дархан-Уул аймаг дахь Уул уурхай эрчим хүчний политехник коллеж	47.6	52.1	47.8	41.8
Дорноговь аймаг дахь политехник коллеж	57.6	61.4	47.8	60.9
Дорнод аймаг дахь мэргэжлийн боловсролын сургууль	72.4	78.6	63.3	71.8
Дорнод аймаг дахь политехник коллеж	63.5	67.9	63.3	58.2
Дундговь аймаг дахь политехник коллеж	51.5	64.3	36.7	47.3
Завхан аймаг дахь политехник коллеж	60.0	65.0	58.9	54.5
Завхан аймгийн Тосонцэнгэл суман дахь мэргэжлийн боловсролын сургууль	52.6	54.3	50.0	52.7
Орхон аймаг дахь мэргэжлийн боловсролын сургууль	72.4	76.4	76.7	63.6
Орхон аймаг дахь ХАА-н мэргэжлийн боловсролын сургууль	64.1	65.0	71.1	57.3
Өвөрхангай аймаг дахь политехник коллеж	74.4	84.3	71.1	64.5
Өмнөговь аймаг дахь политехник коллеж	54.1	51.4	58.9	53.6
Өмнөговь аймаг дахь Скиллстек мэргэжлийн боловсролын сургууль	74.0	71.4	87.0	66.7
Сүхбаатар аймаг дахь мэргэжлийн боловсролын сургууль	53.8	59.3	58.9	42.7
Сэлэнгэ аймаг дахь Зүүнхараа политехник коллеж	49.7	60.7	45.6	39.1
Сэлэнгэ аймаг дахь мэргэжлийн боловсролын сургууль	60.6	64.3	60.0	56.4
Сэлэнгэ аймгийн Шаамар суман дахь мэргэжлийн боловсролын сургууль	50.6	55.0	52.2	43.6
Төв аймаг дахь политехник Коллеж	51.8	58.6	57.8	38.2
Төв аймгийн Баянчандмань суман дахь политехник коллеж	55.3	65.0	50.0	47.3
Төв аймгийн Заамар суман дахь мэргэжлийн боловсролын сургууль	43.2	47.9	45.6	35.5
Төв аймгийн Эрдэнэ суман дахь мэргэжлийн боловсролын сургууль	54.1	58.6	44.4	56.4
Увс аймаг дахь Улаангом политехник коллеж	45.0	41.4	50.0	45.5
Ховд аймаг дахь Хөгжил политехник коллеж	53.2	60.0	51.1	46.4
Хөвсгөл аймаг дахь политехник коллеж	53.8	63.6	58.9	37.3
Хэнтий аймаг дахь политехник коллеж	47.9	52.9	50.0	40.0
Хэнтий аймгийн Бор-Өндөр суман дахь мэргэжлийн боловсролын сургууль	59.7	71.4	44.4	57.3
Эрдэнэт цогцолбор дээд сургуулийн харьяа политехник коллеж	57.1	63.6	58.9	47.3

Хүснэгт дэх мэдээллээс сургалтын байгууллага тус бүрээс хамрагдсан багш нарын амжилтыг агуулгаар харьцуулан үзэхэд:

- Багш нарын чадамжийн үнэлгээний ерөнхий үр дүнг сургуулиар харьцуулсан дүнгээр Өвөрхангай аймаг дахь политехник коллежийн гүйцэтгэлийн дундаж 74.4 хувь байгаа бол Баян-Өлгий аймаг дахь мэргэжлийн боловсролын сургуулийн ерөнхий гүйцэтгэлийн дундаж 32.9 хувьтай гарсан байна.
- Монгол хэл бичгийн шалгалтын үр дүнгээр Өвөрхангай аймгийн политехник коллежийн багш нар 84.3 хувийн амжилтаар бусад сургалтын байгууллагын багш нараас дээгүүр үнэлгээтэй байгаа бол Баян-Өлгий аймаг дахь мэргэжлийн боловсролын сургуулийн багш нар 26.4 хувийн үр дүнтэй үнэлэгдсэн байна.
- Хууль, эрх зүйн мэдлэг, ойлголтыг шалгасан даалгаврын гүйцэтгэлээр Өмнөговь аймаг дахь “Скиллстек” мэргэжлийн боловсролын сургуулийн багш нар 87 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн бол Баян-Өлгий аймгийн мэргэжлийн боловсролын сургуулийн багш нар 34.4 хувьтай үнэлэгджээ.
- Цахим ур чадварыг шалгасан даалгавруудын гүйцэтгэлээр Дорнод аймгийн мэргэжлийн боловсролын сургуулийн багш нар 71.8 хувьтай үнэлэгдсэн бол Төв аймгийн Заамар суман дахь мэргэжлийн боловсролын сургуулийн багш нар 35.5хувьтай үнэлэгдсэн байна.

ДӨРӨВ. ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын сургалтын чанар, үр дүнг үнэлэх суурь шалтгаан нь нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбараас боловсролын салбарт шилжин ирсэнтэй холбоотойгоор сургалтын байгууллагуудын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох, үнэлгээний чиглэлээр суурь мэдээллийн сан бүрдүүлэх, үнэлгээний үр дүнд үндэслэн тайлан, зөвлөмж боловсруулж салбарын түвшинд цаашид авч хэрэгжүүлэх бодлого, баримтлах чиглэлийг боловсруулахтай холбоотой юм.

Мэргэжлийн хөтөлбөрүүдийг сонгохдоо “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаа” “Монгол Улс дахь ур чадварын эрэлт”-ийн судалгааны тайлангийн сүүлийн 2-3 жилийн үр дүнд үндэслэсэн билээ.

Мэргэжлийн болон техникийн боловсролын салбарт хийсэн чанарын үнэлгээг зохион байгуулахдаа цогц байдлаар буюу Гурван хэсгийн загварт нийцүүлэн, өөр хоорондын хамаарлыг судлах, дүн шинжилгээ хийхийг зорьсон билээ. Энэ хүрээнд гарцын түвшинд суралцагчийн чадамж, багшийн чадамж, удирдах ажилтны чадамжийн үнэлгээний үр дүнд дэлгэрэнгүй шинжилгээ хийлээ.

Үнэлгээг зохион байгуулснаар бүх түвшинд судалгааны үр дүнг ашиглах, нотолгоонд суурилсан төлөвлөлт хийх, түүнийг хэрэгжүүлэх, засан сайжруулах, нөөцийн хуваарилалтыг зөв оновчтой хийх зэрэг боломжийг олгож байгаагаас гадна мэргэжлийн хөтөлбөрийн боловсруулалт, хэрэгжилт, багшлахуй, суралцахуйг сайжруулахад чухал дэмжлэг үзүүлнэ гэдэгт итгэж байна.

Судалгааны үр дүнгээс дараах ерөнхий дүгнэлт, зөвлөмжийг гаргаж байна.

Үүнд:

1. 21 аймагт мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үйл ажиллагаа явуулж байгаа сургалтын байгууллагыг сонгон авч чанарын үнэлгээ зохион байгуулснаас 45,5 хувь нь мэргэжлийн боловсролын сургууль, 54,5 хувь нь политехник коллеж гэсэн ангилалд хамаарч байна.
2. Чанарын үнэлгээнд хамрагдсан 1.429 суралцагч, 183 багш, 63 удирдах ажилтан бичгийн шалгалт болон асуулга судалгаанд хамрагдсан байна.
3. Судалгаанд хамрагдсан сургалтын байгууллагын суралцагчдын бичгийн шалгалтын үнэлгээний ерөнхий дундаж 66.2 хувьтай гарснаас эмэгтэй суралцагчдын амжилт 68.5 хувьтай, эрэгтэй суралцагчдын амжилт 64.9 хувь байна.
4. Хэдийгээр судалгаанд хамрагдсан эрэгтэй, эмэгтэй суралцагчдын хүйсийн харьцаа ялгаа их байгаа боловч бичгийн шалгалтын үр дүнг байршил, сургалтын байгууллагын өмчийн хэлбэр, байгууллагын ангилал зэрэг үзүүлэлтийг хүйсээр дэлгэрүүлэн шинжилгээ хийж үзэхэд эмэгтэй суралцагчдын амжилт эрэгтэй суралцагчдынхаас дээгүүр байна.
5. Суралцагчдаас авсан онолын шалгалтын гүйцэтгэлийн дундаж 40.3 хувьтай, ур чадварын үнэлгээний гүйцэтгэлийн дундаж 92.0 хувьтай үнэлэгдсэн байна.
6. Онолын шалгалтын үр дүн доогуур үзүүлэлттэй байгаа нь танхимаар судлах цаг, чадамжийн хөтөлбөрийн агуулгын багтаамж, багшийн заах арга зүй, орчин зэргээс хамаарах магадлал өндөр тул цаашид үр дүнг дэлгэрүүлэн судлах шаардлагатайг харуулж байна. Ур чадварын шалгалтын үр дүн хэдийгээр өндөр гарсан боловч

чадамжийн хөтөлбөр, чадамжийн нэгжийн агуулгаар дэлгэрүүлэн шинжилгээ хийх нь зүйтэй юм.

7. Суралцагчдаас авсан бичгийн шалгалтын үр дүнг сургалтын байгууллагын өмчийн хэлбэрээр ангилан харьцуулахад төрийн өмчийн сургалтын байгууллагын суралцагчдын гүйцэтгэлийн дундаж 66.2 хувьтай, төрийн бус өмчийн сургалтын байгууллагын суралцагчдын амжилт 64.5 хувьтай байна.
8. Танин мэдэхүйн түвшнээр суралцагчдын гүйцэтгэлийг харьцуулахад хэрэглээний даалгаврын гүйцэтгэл хамгийн өндөр буюу 44.7 хувьтай байгаа бол үнэлэх түвшний даалгавар 31.1 хувьтай гарсан байна.
9. Мөн чадамжийн хөтөлбөрөөр суралцагчдын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхээс гадна асуудлыг ойлгох, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, аливааг шинжлэх ухааны үндэслэлтэй тайлбарлах, тооцоо хийх зэрэг танин мэдэхүйн дээд эрэмбийн чадваруудыг хөгжүүлэхэд анхаарч хөтөлбөрийн боловсруулалт, түүнийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах хэрэгцээ байгааг илэрхийлж байна.
10. Танин мэдэхүйн түвшин түүнд харгалзах чадварын гүйцэтгэлийг сайжруулах шаардлага байгааг 2022 оны 10 дугаар сард зохион байгуулсан ерөнхий боловсролын сургуулийн чанарын үнэлгээний үр дүнгээс харж болно. Тухайлбал, тус судалгаанд мэргэжлийн боловсролын сургуулийн 44 байгууллагын 3.962 суралцагчаас авсан цогц чадамжийг илрүүлэх бичгийн шалгалтын гүйцэтгэлийн дундаж 27.79 хувьтай үнэлэгдсэн байгаагаас асуудал шийдвэрлэх чадварын гүйцэтгэл 21.59 хувь, хамтран суралцах чадварыг үнэлсэн даалгавруудын гүйцэтгэл 57.23 хувь, мэдээлэлтэй ажиллах, чадварын шалгасан даалгавруудын гүйцэтгэл 42.89 хувьтай гарсан байна. Дээрх цогц чадамжуудыг үнэлсэн үнэлгээний үр дүнд нэлээд анхаарал татахуйц үзүүлэлт байгаа нь асуудлыг олж харах чадвар 52.18 хувьтай, асуудлыг харьцуулж сонгох чадварын гүйцэтгэл 24.39 хувь, баримт нотолгоо нэмэх чадварын гүйцэтгэл 11.25 хувь, дүгнэлт гаргах чадвар 1.46 хувьтай үнэлэгдсэн явдал юм.
11. Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 17.1-д заасан мэргэжлийн болон техникийн боловсролын үнэлгээнд тавих нийтлэг шаардлагыг тодорхойлох, мөн тус хуулийн 4.4-д заасан үнэлгээг хийж хэрэгжүүлэхэд энэхүү мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын чанарын үнэлгээ нь суурь мэдээлэл болохоор байна.
12. Энэ удаагийн үнэлгээнд сонгон авсан 8 мэргэжлийн хөтөлбөрийн хүрээнд чадамжийн хөтөлбөр, чадамжийн нэгж болон үнэлгээний шалгуур, үзүүлэлт тус бүрээр дэлгэрэнгүй шинжилгээ хийснээр тухайн байгууллагын хөтөлбөрийн хэрэгжилт, цаашид анхаарах агуулга, танин мэдэхүйн түвшин зэргийг тодорхойлсноор сургалтын байгууллагын менежмент, багшийн тасралтгүй хөгжлийг хангах зөв оновчтой бодлогыг хэрэгжүүлж, нөөцийг зөв хуваарилах, сургалтын чанарыг ахиулах зэрэг давуу байдал үүснэ хэмээн үзэж байна.

---o0o---